

1. Санхүүгийн тайлангийн талаар:

“Монголын Цахилгаан Холбоо” ХК-ийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 23 ны өдрийн 173 дугаар хурлын 1 дүгээр тогтоолоор баталсан бол Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын 21 ны өдрийн 181 дугаар хурлын 1 тогтоолоор “Монголын Цахилгаан Холбоо” ХК-ийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг тодотгон баталсан.

Орлого:

2022 онд 19,458.8 сая төгрөгийн нийт орлоготой ажиллахаас гүйцэтгэлээр 18,814.1 сая төгрөгийн орлоготой ажиллаж, нийт орлогын төлөвлөгөө 96.7 хувийн биелэлттэй буюу 644.7 сая төгрөгөөр тасарсан.

Үндсэн үйл ажиллагаанаас 19,216.5 сая төгрөгийн орлоготой ажиллахаас гүйцэтгэлээр 18,495.6 сая төгрөгийн орлоготой ажиллаж, төлөвлөгөө 3.8 хувийн бууралттай буюу 720.9 сая төгрөгөөр тасарсан. Үүнд суурин утасны үйлчилгээний орлого 362.9 сая төгрөгөөр, интернэт үйлчилгээний орлого 278.7 сая төгрөгөөр, КаТв, ОТТ, Лавлахын орлого 430.5 сая төгрөгөөр тус тус тасарсан нь голлон нөлөөлсөн. Бусад орлого 427.3 сая төгрөгөөр өссөн байна.

Үндсэн бус үйл ажиллагаанаас 242.3 сая төгрөгийн орлоготой ажиллахаас гүйцэтгэлээр 318.5 сая төгрөгийн орлоготой ажиллаж, төлөвлөгөө 131 хувийн биелэлттэй буюу 76.2 сая төгрөгөөр биелүүлжээ.

Зардал:

2022 онд төлөвлөгөөгөөр 19,410.7 сая төгрөгийн нийт зардалтай ажиллахаас гүйцэтгэлээр 18,779.9 сая төгрөгийн зардал гарган 96.8 хувийн биелэлттэй буюу 630.8 сая төгрөгийн зардал хэмнэсэн үзүүлэлттэй байна. Үүнээс үндсэн үйл ажиллагааны өртөг 178.6 сая төгрөгөөр, цалингийн сан 187.1 сая төгрөгөөр, үйл ажиллагааны бусад зардал 163.2 сая төгрөгөөр, элэгдлийн зардал 68.9 сая төгрөгөөр хэмнэсэн нь голлон нөлөөлсөн байна.

Ашиг:

Тайлант хугацаанд 8.1 сая төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 10.7 сая төгрөгийн ашигтай ажиллажээ.